



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 01 өдөр

Дугаар А/266

Ховд

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт
шилжүүлсэн хугацааг сунгах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “в” заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 43 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг /шар түвшин-2/-т шилжүүлсэн хугацааг 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 06:00 цагаас эхлэн 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 06:00 цаг хүртэл сунгасугай.

2. Захирамжийг хэрэгжүүлэн ажиллахыг Баруун бүсийн төв Ховд аймгийн Онцгой байдлын газар /хурандаа Б.Алтанбадралт/, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Сумдын Засаг дарга нар, Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ